



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/15/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: П.Амаржаргал Утас: 88106992 Цахим хаяг: amarjargalp@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Албан шаардлага.....	16
4.2 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

᠒᠐᠒᠒. ᠐᠒. 18 № ᠒/54

танай _____ -ны № _____ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ
Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баянхонгор сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:\alban bichig\A4.docx

• 005020653

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



The image shows a red square stamp from the Audit Chamber of Mongolia. The stamp contains the Mongolian text "Аудитын танхим" (Audit Chamber) and "МОНГОЛ" (MONGOLIA). A black ink signature is written over the stamp, crossing it diagonally from the bottom-left to the top-right.

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>114,047,233.17</u>	<u>133,023,435.27</u>
33	АВЛАГА	2,393,252.72	2,779,720.82
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	456,103.33	199,720.82
335	Бусад авлага	1,937,149.39	2,580,000.00
3351	Байгууллагаас авах авлага	1,257,149.39	2,000,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	680,000.00	580,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	111,653,980.45	130,243,714.45
354	Хангамжийн материал	111,653,980.45	130,243,714.45
35410	Бичиг хэргийн материал	16,168,169.11	19,511,869.11
35420	Аж ахуйн материал	47,216,694.00	55,346,228.00
35430	Сэлбэг хэрэгсэл	5,146,003.40	9,762,503.40
35470	Бусад хангамжийн материал	43,123,113.94	45,623,113.94
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,553,751,689.95</u>	<u>1,482,858,000.59</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,553,751,689.95	1,482,858,000.59
392	Биет хөрөнгө	1,469,449,690.06	1,398,656,000.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,426,370,791.10	1,440,885,791.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	-193,599,435.62	-254,033,688.14
39203	Авто-тээврийн хэрэгсэл	140,084,800.00	120,094,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-70,413,787.82	-68,356,253.98
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	197,268,290.00	223,134,190.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-96,944,166.94	-127,792,820.86
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	114,407,299.58	123,212,299.58
39208	Хуримтлагдсан элэгдэл	-64,323,058.57	-73,874,775.27
39214	Бусад үндсэн хөрөнгө	16,900,000.00	16,900,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-301,041.67	-1,513,541.71
393	Биет бус хөрөнгө	84,301,999.89	84,201,999.87
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,250,000.11	-1,350,000.13
39303	Бусад биет бус хөрөнгө	84,052,000.00	84,052,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,667,798,923.12</u>	<u>1,615,881,435.86</u>
413	Өглөг	456,103.33	199,720.82
4136	Бусад өглөг	456,103.33	199,720.82
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	456,103.33	199,720.82
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,667,342,819.79</u>	<u>1,615,681,715.04</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,667,342,819.79	1,615,681,715.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	876,709,433.09	876,709,433.09
51101	Өмч: - төрийн	876,709,433.09	876,709,433.09
512	Хуримтлагдсан үр дүн	426,052,025.84	374,390,921.09
51210	Өмнөх үеийн үр дүн	426,052,025.84	426,052,025.84
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-51,661,104.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	364,581,360.86	364,581,360.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,667,798,923.12</u>	<u>1,615,881,435.86</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,466,006,593.11	2,294,110,657.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	448,583,734.11	46,194,060.00
120	Нийтлэг татварын бус орлого	448,583,734.11	46,194,060.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	448,583,734.11	2,004,060.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,790,600.00	2,004,060.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	442,793,134.11	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	00.00	9,526,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	00.00	34,664,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,017,422,859.00	2,247,916,597.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	378,053,259.00	411,880,797.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	139,111,177.00	411,880,797.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	238,942,082.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,639,369,600.00	1,836,035,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,639,369,600.00	1,836,035,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,046,113,308.52	2,307,506,761.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,046,113,308.52	2,307,506,761.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,958,121,654.11	2,252,911,203.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	601,480,951.95	644,200,501.02
210101	Үндсэн цалин	601,480,951.95	644,200,501.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,957,848.96	86,817,643.64
210201	Тэтгэврийн даатгал	53,571,976.09	61,634,607.62
210202	Тэтгэмжийн даатгал	6,359,486.84	6,848,876.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,885,989.47	5,233,821.02
210204	Ажилгүйдлийн даатгал	1,100,301.76	1,188,685.05
210205	Эрүүл мэндийн даатгал	11,040,094.80	11,911,653.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,096,290.62	75,094,369.48
210301	Гэрэл, цахилгаан	13,695,160.12	7,656,057.48
210302	Түлш, халаалт	56,374,174.50	61,182,640.00
210303	Цэвэр, бохир ус	3,026,956.00	6,255,672.00
2104	Хангамж, бараа материалын зардал	123,893,900.42	656,325,783.39
210401	Бичиг хэрэг	16,260,520.00	13,458,788.00
210402	Тээвэр, шатахуун	30,484,900.00	25,880,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,521,480.42	12,702,735.39
210404	Ном, хэвлэл	1,871,500.00	327,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	58,246,200.00	566,242,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,247,400.00	37,714,960.00
210408	Бараа материал акталсны зардал	1,261,900.00	00.00
2105	Нормативт зардал	3,920,000.00	00.00
210502	Хоол, хүнс	3,140,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	780,000.00	00.00

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,610,640.00	7,789,750.00
210604	Урсгал засвар	13,610,640.00	7,789,750.00
2107	Томилолт, зочны зардал	465,000.00	200,000.00
210702	Дотоод албан томилолт	465,000.00	200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	879,713,522.00	366,322,975.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	879,713,522.00	361,950,332.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	1,204,565.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	623,004.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	310,178.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,598,500.00
210807	Газрын төлбөр	00.00	286,396.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	184,983,500.16	416,160,181.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	82,960,782.00	295,066,592.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,014,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	101,022,718.16	120,079,589.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	87,991,654.41	54,595,557.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,290,000.00	27,012,394.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	22,712,794.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,290,000.00	4,299,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	83,701,654.41	27,583,163.86
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	68,095,472.41	16,437,045.66
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	15,606,182.00	11,146,118.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	419,893,284.59	-13,396,104.75
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	16,859,364.28	38,265,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	16,859,364.28	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-16,859,364.28	-38,265,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	403,033,920.31	-51,661,104.75

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,023,213,459.00	2,251,920,657.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,790,600.00	2,004,060.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,790,600.00	2,004,060.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,790,600.00	2,004,060.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,790,600.00	2,004,060.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,017,422,859.00	2,249,916,597.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	378,053,259.00	413,880,797.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	139,111,177.00	413,880,797.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	238,942,082.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,639,369,600.00	1,836,035,800.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,639,369,600.00	1,836,035,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,966,853,559.00	2,212,260,757.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,966,853,559.00	2,212,260,757.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,878,861,904.59	2,155,665,199.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	585,652,800.49	630,043,495.73
210101	Үндсэн цалин	585,652,800.49	630,043,495.73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,084,869.06	83,641,996.74
210201	Тэтгэврийн даатгал	52,322,901.31	59,057,304.23
210202	Тэтгэмжийн даатгал	6,193,486.84	6,707,944.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,725,149.29	5,118,555.42
210204	Ажилгүйдлийн даатгал	1,104,896.02	1,164,598.65
210205	Эрүүл мэндийн даатгал	10,738,435.60	11,593,593.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,096,290.62	75,094,369.48
210301	Гэрэл, цахилгаан	6,661,287.12	6,134,067.48
210302	Түлш, халаалт	63,408,047.50	62,704,630.00
210303	Цэвэр, бохир ус	3,026,956.00	6,255,672.00
2104	Хангамж, бараа материалын зардал	122,777,100.42	724,996,113.39
210401	Бичиг хэрэг	16,116,120.00	14,077,488.00
210402	Тээвэр, шатахуун	30,484,900.00	25,680,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,583,980.42	12,702,735.39
210404	Ном, хэвлэл	1,871,500.00	1,927,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	58,246,200.00	666,242,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,474,400.00	4,366,590.00
2105	Нормативт зардал	8,820,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,820,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,132,540.00	11,036,750.00
210602	Тавилга	499,500.00	1,140,000.00
210604	Урсгал засвар	8,633,040.00	9,896,750.00
2107	Томилолт, зочны зардал	465,000.00	200,000.00
210702	Дотоод албан томилолт	465,000.00	200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	897,712,922.00	390,307,321.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	897,712,922.00	385,934,678.80
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	1,204,565.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	623,004.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	310,178.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,598,500.00
210807	Газрын төлбөр	00.00	286,396.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	106,120,382.00	240,345,152.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	104,120,382.00	238,851,152.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,494,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	87,991,654.41	56,595,557.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,290,000.00	27,012,394.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	22,712,794.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,290,000.00	4,299,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	83,701,654.41	29,583,163.86
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	68,095,472.41	16,437,045.66
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	15,606,182.00	13,146,118.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	56,359,900.00	39,659,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	56,359,900.00	39,659,900.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	56,359,900.00	39,659,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	56,359,900.00	39,659,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	56,359,900.00	39,659,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-56,359,900.00	-39,659,900.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,709,433.09	370,179,787.71	8,598,553.93	1,255,487,774.73
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	5,598,426.85	5,598,426.85
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	876,709,433.09	370,179,787.71	14,196,980.78	1,261,086,201.58
C04	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	00.00	-5,598,426.85	00.00	-5,598,426.85
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	411,855,045.06	411,855,045.06
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,709,433.09	364,581,360.86	426,052,025.84	1,667,342,819.79
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	876,709,433.09	364,581,360.86	426,052,025.84	1,667,342,819.79
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	876,709,433.09	364,581,360.86	426,052,025.84	1,667,342,819.79
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-51,661,104.75	-51,661,104.75
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,709,433.09	364,581,360.86	374,390,921.09	1,615,681,715.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,936,122,700.00	1,821,602,814.34	114,519,885.66	94.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,936,122,700.00	1,821,602,814.34	114,519,885.66	94.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,909,110,300.00	1,794,590,420.34	114,519,879.66	94.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	630,498,500.00	630,043,495.73	455,004.27	99.93
210101	Үндсэн цалин	630,498,500.00	630,043,495.73	455,004.27	99.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,763,900.00	83,641,996.74	2,121,903.26	97.53

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	60,352,300.00	59,057,304.23	1,294,995.77	97.85
210202	Тэтгэмжийн даатгал	6,352,900.00	6,707,944.52	-355,044.52	105.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,082,300.00	5,118,555.42	-36,255.42	100.71
210204	Ажилгүйдлийн даатгал	1,270,600.00	1,164,598.65	106,001.35	91.66
210205	Эрүүл мэндийн даатгал	12,705,800.00	11,593,593.92	1,112,206.08	91.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,431,800.00	75,094,369.48	1,337,430.52	98.25
210301	Гэрэл, цахилгаан	7,609,100.00	6,134,067.48	1,475,032.52	80.61
210302	Түлш, халаалт	63,095,800.00	62,704,630.00	391,170.00	99.38
210303	Цэвэр, бохир ус	5,726,900.00	6,255,672.00	-528,772.00	109.23
2104	Хангамж, бараа материалын зардал	803,083,300.00	724,996,113.39	78,087,186.61	90.28
210401	Бичиг хэрэг	13,832,000.00	14,077,488.00	-245,488.00	101.77
210402	Тээвэр, шатахуун	25,680,000.00	25,680,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,729,600.00	12,702,735.39	26,864.61	99.79
210404	Ном, хэвлэл	2,148,000.00	1,927,000.00	221,000.00	89.71
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	744,326,900.00	666,242,300.00	78,084,600.00	89.51
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,366,800.00	4,366,590.00	210.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,899,600.00	35,896,650.00	2,950.00	99.99
210602	Тавилга	20,000,000.00	19,999,900.00	100.00	100.00
210604	Урсгал засвар	15,899,600.00	15,896,750.00	2,850.00	99.98
2107	Томилолт, зочны зардал	200,000.00	200,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	200,000.00	200,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,816,000.00	4,372,643.00	443,357.00	90.79
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	350,000.00	150,000.00	70.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,479,400.00	1,204,565.00	274,835.00	81.42
210804	Тээврийн хэрэгслийн татвар	632,100.00	623,004.00	9,096.00	98.56
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	314,500.00	310,178.00	4,322.00	98.63
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,600,000.00	1,598,500.00	1,500.00	99.91
210807	Газрын төлбөр	290,000.00	286,396.00	3,604.00	98.76
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	272,417,200.00	240,345,152.00	32,072,048.00	88.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	270,917,200.00	238,851,152.00	32,066,048.00	88.16
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	1,494,000.00	6,000.00	99.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,012,400.00	27,012,394.00	6.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,012,400.00	27,012,394.00	6.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,712,800.00	22,712,794.00	6.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,299,600.00	4,299,600.00	0.00	100.00



	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,936,122,700.00	1,821,602,814.34	114,519,885.66	94.09
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,904,455,500.00	1,819,598,754.34	84,856,745.66	95.54
132001	Орон нутгийн төсвөөс	1,904,455,500.00	1,819,598,754.34	84,856,745.66	95.54
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	31,667,200.00	2,004,060.00	29,663,140.00	6.33
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,667,200.00	00.00	30,667,200.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	2,004,060.00	-1,004,060.00	200.41
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	60.00	68.00	-8.00	113.33
620001	Удирдах ажилтан	12.00	12.00	0.00	25.00
620002	Гүйцэтгэх ажилтан	39.00	47.00	-8.00	186.67
620003	Үйлчлэх ажилтан	9.00	09.00	9.00	50.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	378,053,259.00	400,734,678.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	378,053,259.00	400,734,678.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	378,053,259.00	400,734,678.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	378,053,259.00	400,734,678.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	378,053,259.00	400,734,678.80
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	378,053,259.00	411,880,797.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	378,053,259.00	411,880,797.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	139,111,177.00	411,880,797.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	238,942,082.00	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн ба төсвийн зарцуулалтын эрхийн хүсэлтэд нэгдүгээр гарын үсгийг 2021.12.16-ны өдрийг хүртэл Ц.Насанбаяр, 2021.12.17-ноос эхлэн Э.Батцэцэг, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Даваажаргал нар тус тус зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

“Олон Улсын чанарын удирдлагын стандартыг нэвтрүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэн, иргэдийнхээ ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлсэн, өндөр мэдлэг, ур чадвартай, мэргэшсэн, төрийн албан хаагчид, сахилга хариуцлагатай тогтвортой засаглалыг төлөвшүүлэхэд оршино”.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,037,292.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 20,372.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 14,261.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 22,910.6 мянган төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдал 16,037.4 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 51,917.5 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	114,047.30	133,023.40	18,976.10
Мөнгөн хөрөнгө	-	-	0.00
Авлага	2,393.20	2,779.70	386.50
Урьдчилгаа	-	-	0.00
Бараа материал	111,653.90	130,243.70	18,589.80
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,553,751.60	1,482,858.00	-70,893.60
Үндсэн хөрөнгө	1,980,583.10	2,009,779.00	29,195.90
Хуримтлагдсан элэгдэл	-426,831.40	-526,921.00	-100,089.60
Нийт хөрөнгө	1,667,798.90	1,615,881.40	-51,917.50
Өр төлбөр	0	0	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,667,342.80	1,615,681.70	-51,661.10
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,667,798.90	1,615,881.40	-51,917.50

Авлагын дансны үлдэгдэл 386.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нягтлан бодогчийг түр орлон ажиллаж байсан Бямбажаргалын цалингийн урьдчилгааны авлага 580.0 мянга, шинэ суурьшлын бүсийн хашааны төлбөр болох 2,000.0 мянган төгрөг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр орж ирсэнтэй холбоотойгоор нэмэлт санхүүжилтийн дансны санхүүжилтийн авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 18,589.8 мянган төгрөг болж 16,004.9 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал 3,343.7, аж ахуй материал 8,129.5 мянга, сэлбэг хэрэгслийн материал 4,616.5 мянга, бусад хангамжийн материал 2,500.0 мянган

төгрөгөөр өссөн бөгөөд, аж ахуй материал дансанд 33,964.0 мянган төгрөгийн халдвар хамгаалалтын хэрэглэл аймгийн Онцгой комиссоос шилжүүлэн үнэ төлбөргүй хүлээн авч зарцуулсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,009,779.0 мянган төгрөг болж өмнөх оноос 29,195.9 мянган төгрөгөөр өссөн нь 39,659.9 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.10.15-ны өдрийн 115 дугаар тогтоолоор 9,526.0 мянган төгрөгийн малын гарал үүслийн гэрчилгээний систем нэвтрүүлэх тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авч орлогоор бүртгэсэн, Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.10.15-ны өдрийн 117 дугаар тогтоолоор УАЗ-390942-08 маркийн 70-77БНХ улсын дугаартай автомашины дуудлага худалдаанд оруулж, данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,615,881.4 мянган төгрөг болж 51,661.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 51,661.1 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд төсвийн нийт эх үүсвэрийг 1,895,747.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 122,865.7 мянган төгрөгөөр бууруулж 1,772,882.1 мянган төгрөгөөр анх батлагдаж 2021 оны 07 дугаар сарын 29-ны 3/7 тоот сумын ИТХ-ын хуралдааны тогтоолоор тодотгол хийгдэж 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/257 дугаар сумын Засаг даргын захирамжаар төсвийн зохицуулалт хийгдэж 1,936,122.7 мянган төгрөгөөр батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг 1,936,122.7 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,936,122.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоор 2,004.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,821,602.8 мянган төгрөгийг зарцуулж 16,437.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлж төсвийн гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор 98,082.8 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,821,602.8 мянган төгрөг буюу 94.1 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшлын зардлыг 455.0 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 2,121.9 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,337.4 мянга, хангамж бараа материалын зардлыг 78,087.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 433.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 32,072.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн Төрийн сан банкин дахь 100032055405 тоот дансанд тайлант хугацаанд 411,880.7 мянган төгрөгийн орлого орж 398,734.7 мянган төгрөгийг зарцуулан 11,146.1 мянган төгрөгийг төвлөрүүлэн 2,000.0 мянган төгрөгийг санхүүжилтийн авлагаар тусгасан байна.

Хүснэгт 2. Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зарлагын үзүүлэлт /мянган төгрөг/

Санхүүжилтийн эх үүсвэр	Орлого	Зарлага	Санхүүжилтийн авлагаар тусгасан	Төвлөрүүлсэн
2020 оны нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл	3,341.18			3,341.18
Иргэдээс-Шинэ суурьшлын бүсийн хашааны үнэ	274,100.00	272,100.00	2,000.00	
Сумын сургууль, цэцэрлэгүүдийн сумын онцгой комисст өгсөн хандив тусламж	10,870.00	10,815.10		54.90
Аймгийн Статистикийн хэлтсээс мал тооллогын зардал	1,113.61	1,113.61		
Аймгийн ЗДТГ-аас "Утаагүй Баянхонгор" төслийн санхүүжилт	63,199.00	57,545.30		5,653.70
Аймгийн онцгой комисс- Баянхонгор аймаг дахь Онцгой байдлын газар	16,392.20	16,326.70		65.50
Хүүхэд гэр, бүл хөгжил, залуучуудын хөгжлийн газраас хамтарсан багийн ажлын зардал	6,000.00	6,000.00		
ХЗДХЯ-наас Дуурсах 3-р багт хэрэгжиж буй "Зүглэ-Зүтгэ-Зүлэг" төслийн санхүүжилт	3,500.00	3,500.00		
Багуудаас хүчингүй болгосон баланк, тоотны үнэ	64.80	64.80		
Аймгийн ЗДТГ-аас Хяналт ажиглалтын шатахууны зардал багийн ЗД нарт	2,000.00	2,000.00		
Баянхонгор аймаг дахь Онцгой байдлын газраас идэвхтэн нарын нэгжийн төлбөр	1,200.00	1,200.00		
Аймгийн ЗДТГ А/44 тоот захирамжаар	1,000.00			1,000.00
Тендерийн баримт бичгийн орлого	455.00	419.20		35.80
Зоригтболд ХХК -аас тоглоомын талбайн санхүүжилт	7,500.00	7,500.00		
А.Баасандоржоос тоглоомын талбайн санхүүжилт	7,500.00	7,500.00		
С.Ганбатаас тоглоомын талбайн санхүүжилт	7,000.00	7,000.00		
Аймгийн ИТХ-аас Сэтгэлзүйн зөвлөгөө өгөх өрөөнд шаардагдах зардал	5,000.00	5,000.00		
Буулгасан барилгын хогийг хогийн цэгт хаясны төлбөр	1,550.00	650.00		900.00
Данс андуурсан төлбөр 6163 БНХ	95.00			95.00
Нийт	411,880.79	398,734.71	2,000.00	11,146.08

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд нийт 53 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 91.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 2,345,771.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 299,658.4 мянган төгрөгөөр буюу 12.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд, хангамж бараа материалын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бараа үйлчилгээний бусад зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол эд хогшил худалдан авах зардал, албан томилолтын зардал нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 1,936,122.7 мянган төгрөгийн 151 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна.Үүнд:

Тайланд онд 1,904,455.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 31,667.2 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 1,821,602.8 мянган төгрөг зарцуулж, орон нутгийн төсөвт 114,519.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байгаа нь нийт зардлын 6.2 хувийг хэмнэсэн гэж үзэхээр байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1¹ гэсэн заалттай нийцэхгүй байна.

- Тайлант онд тогтмол зардалд 76,431.8 мянган төгрөг батлагдсан ба нийт батлагдсан төсвийн 20 хувь нь 15,286.3 мянган төгрөг байна. Тус онд 13,948.9 мянган төгрөгийн хэмнэлт үүсгээгүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын "1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах" гэсэн заалттай бүрэн нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,693.0 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илэрснээс, 4,693.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 заалт бүхий зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 44,466.9 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс 30,518.0 мянган төгрөгийн санхүүгийн тайлангийн аудитын, 13,948.9 мянган төгрөгийн нийцлийн аудитын алдаа зөрчил илэрснээс 8,518.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 35,948.9 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 заалт бүхий зөвлөмжийг хүргүүллээ.

4.1 Албан шаардлага

4.1.1. Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас ажилчдын хүүхдийн бэлэг, ахмад настны хүндэтгэл үзүүлэх зардал, сургалтын хоолны зардал, спортын арга хэмжээний зардал, хайрхны тахилгын зардал гэх мэт зардлыг санхүүжүүлэн 8,518.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Сангийн сайдын 2021.04.20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7.1. Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна гэсэн заалтыг тус тус зөрчсөн нь санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага өгөв.

4.2 Зөвлөмж

4.2.1. Баянхонгор аймгийн Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн "Гадна тохижилт хийх тухай" 204 тоот албан бичгээр барилга, угсралтын кампаниудад шаардлага хүргүүлж хэрэгжилтийг 2021

1. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах

оны 06 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг даалгасан байна. Тус албан бичгийн дагуу өөрийн гүйцэтгэлээр барьсан орон сууцны гадна тохижилтын ажлыг хийж гүйцэтгээгүй Зоригтболд ХХК-аас 7,500.0 мянга, иргэн А.Баасандоржоос 7,500.0 мянга, С.Ганбатаас 7,000.0 мянга нийт 22,000.0 мянган төгрөгийн хүү торгуулийн орлогыг Баянхонгор сумын нэмэлт санхүүжилтийн Төрийн сан банк дахь 10032055405 тоот дансанд төвлөрүүлэн Номгон 1-р баг, Рашаант 10-р багуудад хийгдсэн тоглоомын талбайн тохижилтыг санхүүжүүлж орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлээгүй зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн “41.2.1.Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн нь санхүүгийн тайлангийн Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг өөрийн дансаар дамжуулан зориулалт бусаар зарцуулахгүй байх зөвлөмж өгөх.

4.2.2 Тайлант онд тогтмол зардалд 76,431.8 мянган төгрөг батлагдсан ба нийт батлагдсан төсвийн 20 хувь нь 15,286.3 мянган төгрөг байна. Тус онд 13,948.9 мянган төгрөгийн хэмнэлт үүсгээгүй байна.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын “1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалттай бүрэн нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний талаар Засгийн газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

Аудитаар өгсөн зөвлөмжийн бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2022 оны 12 дугаар сарын 05-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс				Зөвлөмж			
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Баянхонгор сумын ЗДТГ	2	30,518.0	0	0	1	0	1	22,000.0	1	8,518.0
	Дүн										
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Баянхонгор сумын ЗДТГ	1	13,948.9	0	0	0	0	0	0	1	13,948.9
	Дүн										
	НИЙТ ДҮН	3	44,466.9	0	0	0	0	1	22,000.0	2	22,466.9